

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/024/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд
Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 11-315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 11-325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn

Солид Юнити Аудит ХХК-ийн захирал: Э.Мөнхтогтох
Утас: 99063227 Цахим хаяг: munkhtogtokh.e@solidunity.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
Асуудлыг онцолсон хэсэг	2
Аудитын гол асуудал.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
3.1 Албан шаардлага	10
3.2. Зөвлөмж.....	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/302
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу өөрчлөлт, шинэчлэлтийг тусгаж, үйл ажиллагааны онцлог, үйлчилгээний орлого, өртөг тооцоолол, зардал хуваарилалт, бараа материал, үндсэн хөрөнгө зэрэг бодлогод өөрчлөлтүүдийг оруулж, мөрдөж эхэлсэн байна.

Байгууллагын захирлын 2024 оны А/03 тоот тушаалаар үйлчилгээний хөлсийг шинэчлэн тогтоосон бөгөөд Нийслэлийн харьяа төрийн байгууллагуудтай хамтран хуримын үйлчилгээ үзүүлж, 61.5 сая төгрөгийн үйлчилгээний орлого бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Байгууллага нь борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэхдээ нэмэгдсэн өртгийн албан татварын бүртгэлийг программаар бус ажилтан гар ажиллагаагаар салгаж журнал хөтөлж байгаагаас үүссэн тооцооллын зөрүүтэй дүн нь материаллаг бус, хараат бус аудиторовын дүгнэлтэд нөлөөлөхгүй гэж үзсэн.

ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДОН
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ү.ОЮУНЗУЛ ТАНАА

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 92.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	2023 оны 12-р дугаар сарын 31	2024 оны 12-р дугаар сарын 31
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	846,817,597.79	613,396,579.87
2	Татвар, НДШ-ийн авлага	14,583,863.60	12,497,244.41
3	Бусад авлага	4,862,121.82	1,161,000.00
4	Бараа материал	156,913,220.25	447,324,428.25
5	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,568,493.15	-
5	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,025,745,296.61	1,074,379,252.53
6	Үндсэн хөрөнгө	2,294,413,714.17	2,250,896,592.62
7	Биет бус хөрөнгө	1,356,184,666.57	1,367,804,666.53
8	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
9	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,650,598,380.74	3,618,701,259.15
10	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,676,343,677.35	4,693,080,511.68
11	Дансны өглөг	-	-
12	Татварын өр	54,383,942.45	33,010,709.50
13	Урьдчилж орсон орлого	5,260,000.00	11,970,000.00
14	Богино хугацаат хойшлогдсон орлого	-	4,581,111.10
15	Богино хугацаат өр төлбөрийн дүн	59,643,942.45	49,561,820.60
16	Урт хугацаат хойшлогдсон орлого	-	8,016,944.42
17	Өр төлбөрийн нийт дүн	59,643,942.45	57,578,765.02
18	Эздийн өмч		
19	Өмч: а) төрийн	106,219,259.00	106,219,259.00
20	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,132,645,875.51	2,132,645,875.51
21	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	1,347,328,000.00	1,347,328,000.00
22	Тайлант үеийн ашиг, алдагдал	499,208,598.89	167,598,875.76
23	Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг, алдагдал	531,298,001.50	881,709,736.39
24	Эздийн өмчийн дүн	4,616,699,734.90	4,635,501,746.66
25	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,676,343,677.35	4,693,080,511.68

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	2023 оны 12-р дугаар сарын 31	2024 оны 12-р дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,939,099,598.96	1,730,610,387.05
2	Борлуулалтын өртөг	(936,510,511.28)	(1,124,634,715.88)
3	Нийт ашиг	1,002,589,087.68	605,975,671.17
4	Түрээсийн орлого	17,360,399.99	35,800,909.08
5	Хүүний орлого	48,560,414.50	62,490,116.13
6	Бусад орлого	169,645,336.14	242,836,128.54
7	Борлуулалт, маркетингийн зардал	(262,294,608.97)	(281,996,816.30)
8	Ерөнхий ба удирдлагын зардал	(368,417,772.03)	(456,177,202.49)
9	Бусад зардал	(16,873,892.55)	(21,419,704.86)
10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(214,066.79)	-
11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	590,354,897.97	187,509,101.27
12	Орлогын татварын зардал	(59,056,896.47)	(19,910,225.51)
13	Татвар дараах ашиг (алдагдал)	531,298,001.50	167,598,875.76
14	Нэгж хувьцааны ногдох суурь ашиг (алдагдал)	531,298,001.50	167,598,875.76

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2022 оны 12- р сарын 31-ний үлдэгдэл	106,219,259.00	2,133,199,429.51	1,347,328,000.00	549,832,593.45	4,136,579,281.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөөлөл	-	-	-	(51,177,548.56)	(51,177,548.56)
Залруулсан үлдэгдэл	106,219,259.00	2,133,199,429.51	1,347,328,000.00	498,655,044.89	4,085,401,733.40
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	-	-	531,298,001.50	531,298,001.50
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(553,554.00)	-	553,554.00	-
2023 оны 12- р сарын 31-ний үлдэгдэл	106,219,259.00	2,132,645,875.51	1,347,328,000.00	1,030,506,600.39	4,616,699,734.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөөлөл	-	-	-	(5,346,404.00)	(5,346,404.00)
Залруулсан үлдэгдэл	106,219,259.00	2,132,645,875.51	1,347,328,000.00	1,025,160,196.39	4,611,353,330.90
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	-	-	167,598,875.76	167,598,875.76
Зарласан ноогдол ашиг	-	-	-	(143,450,460.00)	(143,450,460.00)
2024 оны 12- р сарын 31-ний үлдэгдэл	106,219,259.00	2,132,645,875.51	1,347,328,000.00	1,049,308,612.15	4,635,501,746.66

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	2023 оны 12-р дугаар сарын 31	2024 оны 12-р дугаар сарын 31
1	Мөнгөн орлогын дүн (+)	2,415,355,254.36	2,301,014,754.04
2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,401,039,144.40	2,295,408,246.64
3	Бусад мөнгөн орлого	14,316,109.96	5,606,507.40
4	Мөнгөн зарлагын дүн (-)	1,685,091,977.74	2,327,292,528.16
5	Ажиллагчдад төлсөн	302,217,921.00	369,753,065.00
6	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	124,923,415.81	161,483,477.12
7	Бараа материалын худалдан авахад төлсөн	974,607,765.16	1,206,096,268.43
8	Ашиглалтын зардалд төлсөн	18,550,328.91	233,092,667.00
9	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	781,377.28	1,360,506.46
10	Хүүний төлбөрт төлсөн	4,856,041.44	6,249,011.61
11	Татварын байгууллагад төлсөн	226,612,828.14	214,166,105.41
12	Даатгалын төлбөрт төлсөн	7,500,000.00	-
13	Бусад мөнгөн зарлага	25,042,300.00	135,091,427.13
14	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	730,263,276.62	(26,277,774.12)
15	Мөнгөн орлогын дүн (+)	48,560,414.50	62,490,116.13
16	Хүлээн авсан хүүний орлого	48,560,414.50	62,490,116.13
17	Мөнгөн зарлагын дүн (-)	166,507,200.00	126,182,899.93
17	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	166,507,200.00	126,182,899.93
18	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(166,507,200.00)	(126,182,899.93)
19	Мөнгөн зарлагын дүн (-)	-	143,450,460.00
20	Төлсөн ноогдол ашиг	-	143,450,460.00
21	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	(143,450,460.00)
22	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	612,316,491.12	(233,421,017.92)
23	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	234,501,106.67	846,817,597.79
24	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	846,817,597.79	613,396,579.87

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган, төгрөгөөр/

Үзүүлэлтүүд		2023 оны гүйцэтгэл	2024 оны зорилт	2024 он		
				Гүйцэтгэл	Хэмнэлт/ (Хэтрэлт)	Хувь
Хуримын тоо		1248	1250	1038	(212)	
1	Нийт орлого					
1.1	Үндсэн үйл ажиллагааны орлого	1,982,515.31	2,104,386.00	1,712,741.53	(391,664.47)	(19)
1.2	Дэлгүүрийн орлого	6,345.54	10,000.00	22,195.91	12,195.91	122
1.3	Сургалтын орлого	378.90	10,000.00	800.00	(9,200.00)	(92)
1.4	Үйл ажиллагааны түрээсийн орлого	17,360.40	15,000.00	35,800.91	20,800.91	139
1.5	Прокатын орлого	5,343.18	5,000.00	10,890.00	5,890.00	118
1.6	Хадгаламжийн хүүгийн орлого	48,560.41	10,000.00	62,490.11	52,490.11	525
1.7	Зогсоолын орлого	163,949.41	110,000.00	187,324.78	77,324.78	70
1.8	Бусад	5,695.93	10,000.00	55,511.35	45,511.35	455
	Нийт орлого	2,230,149.08	2,274,386.00	2,087,754.59	(202,648.45)	(8.2)
1.9	Борлуулалтын буцаалт	(38,759.99)		(177.00)		
1.1	Борлуулалтын хөнгөлөлт	(16,723.35)		(15,840.04)		
	Цэвэр орлого	2,174,665.74		2,071,737.55	(202,648.45)	(8.9)
2	Зардал					
2.1	Цалин-үндсэн	400,169.40	576,900.00	574,902.56	(1,997.44)	(0.3)
2.2	Хоол, унааны хөнгөлөлт	130,832.00	182,760.00	135,651.82	(47,108.18)	(25.8)
2.3	НДШ	65,395.94	94,958.00	84,335.58	(10,622.42)	(11.2)
2.4	Түүхий эд, материалын зардал	558,290.65	809,840.00	583,573.20	(226,266.80)	(27.9)
2.5	Маркетингийн зардал	48,190.27	75,000.00	63,232.31	(11,767.69)	(15.7)
2.6	Тохижилтын зардал	15,000.00	40,000.00	19,205.12	(20,794.88)	(52)
2.7	Томилолтын зардал	5882.25	21,000.00	20,950.04	(49.96)	(0.2)
2.8	Хөдөлмөр аюулгүй байдлын зардал	15,494.00	18,000.00	8,683.72	(9,316.28)	(51.8)
2.9	Ажиллагсадтай холбоотой зардал	3,000.00	25,000.00	24,972.42	(27.58)	(0.1)

Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Үзүүлэлтүүд		2023 оны гүйцэтгэл	2024 оны зорилт	2024 он		
				Гүйцэтгэл	Хэмнэлт/ (Хэтрэлт)	Хувь
2.10	Бичиг хэргийн зардал	1,682.09	5,000.00	4,463.57	(536.43)	(10.7)
2.11	Ашиглалтын зардал	33,501.27	38,000.00	22,748.89	(15,251.11)	(40.1)
2.12	Ус, Хогны зардал	1,974.50	3,500.00	1,887.00	(1,613.00)	(46.1)
2.13	Түлш, шатахууны зардал	781.38	3,500.00	1,360.50	(2,139.50)	(61.1)
2.14	Шуудан холбоо, бичиг хэрэг зар	4,944.68	5,000.00	4,683.34	(316.66)	(6.3)
2.15	Газрын татвар	2,208.60	3,000.00	2,208.57	(791.43)	(26.4)
2.16	Үл хөдлөх хөрөнгийн татвар	16,524.81	17,500.00	16,524.81	(975.19)	(5.6)
2.17	Автомашин татвар	-	-	-	-	-
2.18	Аудит	11,200.00	8,000.00	8,000.00	-	-
2.19	Элэгдлийн зардал	180,832.60	190,000.00	212,338.66	22,338.66	11.8
2.20	Сургалтын зардал томилолт	2450.0	9,000.00	6,640.90	(2,359.10)	(26.2)
2.21	Даатгалын хураамж	4,931.50	9,500.00	2,568.49	(6,931.51)	(73.0)
2.22	Сэлбэг хэрэгсэл	168.30	-	-	-	-
2.23	Урсгал засвар	34,926.50	60,000.00	37,314.94	(22,685.06)	(37.8)
2.24	Бусад	14,628.94	28,000.00	23,561.80	(4,438.20)	(15.9)
2.25	Үйл ажиллагааны бус зардал	1,676.93	-	-	-	-
2.26	Багаж хэрэгсэл	1,700.00	-	-	-	-
2.27	Зогсоол	27,710.17	30,000.00	24,420.20	(5,579.80)	(18.6)
Нийт зардал		1,584,096.78	2,253,458.00	1,884,228.44	(370,285.02)	(16.4)
3	Татвар төлөхийн өмнөх ашиг	590,331.19	20,928.00	187,509.10	166,581.10	796
4	Орлогын татварын зардал	59,033.12	2,092.80	19,910.23	17,817.43	851.4
5	Цэвэр ашиг, алдагдал	531,298.07	18,835.20	167,598.88	148,763.68	789.8
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.73	0.99	0.91	(0.08)	(8.1)
7	нийт авлага	19,445.98	10,000.00	11,220.00		
8	Нийт өглөг	57,718.23	20,000.00	30,874.40		
9	Хөрөнгө оруулалтын дүн	166,507.20	590,000.00	126,182.90		
	Орон тоо	29	32	29		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 75,256.5 мянган төгрөгийн 8 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Бараа материалыг ангиллыг 20,117.6 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгийг дансны ангиллыг 10,564.9 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын шийдвэрээр шилжиж ирсэн тээврийн хэрэгслийг эздийн өмчийн бусад хэсэгт 30,758.9 зөрүүтэй бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын шийдвэрээр шилжиж ирсэн тээврийн хэрэгслийг НББОУС 20-ын дагуу бүртгээгүй, тайлант оны бусад орлого 1,145.3 мянган төгрөгийг хүлээн зөвшөөрөөгүй;
- Тээврийн хэрэгсэлд шинээр тавьсан 7,288.6 мянган төгрөгийн АВС моторыг хөрөнгийн өртөгт капиталжуулаагүй, тайлант жилийн засварын зардлаар бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг 3,768.4 мянган төгрөгөөр дутуу тооцож, элэгдлийн зардал, хуримтлагдсан элэгдлийг уг дүнгээр дутуу бүртгэсэн;
- Хуримын үйлчилгээний орлогыг 1,382.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Орлогын татварын зардлыг 230.1 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй тооцсон.

Аудитаар нийт 28,886.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 22,455.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 6,430.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 28,886.4 мянган төгрөгийн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 200.1 мянган төгрөгөөр бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн “Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх, холбогдох стандарт, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах” зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Мөн тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 4-н төрлийн 26-н ширхэг үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 онд баталсан “Журам шинэчлэх тухай” 271 дүгээр тогтоолын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засан сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д “үнэн зөв байх” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр тайлагнах, ашиглахгүй хөрөнгүүдийг актлах саналыг НӨХГ-т хүргүүлж шийдвэрлүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.1.2 Ажилчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх нарийвчилсан үнэлгээний шалгуур үзүүлэлт, түүнийг үнэлэх журамгүйгээр нийт ажилчдад Удирдах зөвлөлийн 2024 оны А/08 тогтоол, Захирлын 2024 оны А/44 тоот тушаалыг үндэслэн 22,455.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал хавтгайруулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д дэх заалт “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдад үр дүнгийн урамшуулал олгох журам, үнэлэх шалгуур үзүүлэлтийг баталж мөрдөөгүй, үр дүнгийн урамшууллыг хавтгайруулан олгосон зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.2. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1..Бараа борлуулалтын өртгийн холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа борлуулалтын орлогод эзлэх борлуулсан барааны өртөг харилцан адилгүй орлого, өртгийг өөр өөр сард бүртгэсэн байна. Тайлант оны эхний улиралд бараа борлуулалтын орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн хэдий ч 2,761.4 мянган төгрөгийн бараа борлуулалтын өртөг хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалд “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг тодруулгыг бэлтгэх, заавар”-ын “Орлого ба зардлыг тэдгээрийн үүсэн гарч буй шалтгаанаар нь ангилна”, “Орлогын зүйл анги тус бүрд зардлын зүйл ангийг зохицуулах зарчмыг баримтлан бүртгэнэ”, “Бизнесийн тодорхой чиглэлүүдээр зардлын зүйл ангийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж, мэдээлэх ажлыг өртгийн бүртгэлийн хүрээнд зохион байгуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3.”Жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “Үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа борлуулалтын орлого болон өртгийг уялдуулан бүртгэх, орлого өртгийг цаг хэрэгжсэн тухай бүрд нь бүртгэж тайлагнах зөвлөмж өгөв.

2.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэхтэй холбоотой гарсан 3,669.4 мянган төгрөгийн зардлыг ахмадын сангийн зардлаар бус ерөнхий удирдлагын зардалд ажиллагсадтай холбоотой зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.6-д "Аж ахуйн нэгж, байгууллага нь ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ", 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн байх зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ахмад настны тухай хуулийн дагуу Ахмад настны сан байгуулж, уг сангаас зардлыг санхүүжүүлэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материалыг ангилал зөрүүтэй бүртгэсэн.	1	20,117.6	-	-	1	20,117.6	1	20,117.6	-	-	-	-
Үндсэн хөрөнгийг ангилал зөрүүтэй бүртгэсэн	1	10,564.9			1	10,564.9	1	10,564.9	-	-	-	-
ТӨБЗГ-ын шийдвэрээр шилжиж ирсэн тээврийг хэрэгслийг эздийн өмчийн бусад хэсэгт зөрүүтэй бүртгэсэн.	1	30,758.9			1	30,758.9	1	30,758.9	-	-	-	-
ТӨБЗГ-ын шийдвэрээр шилжиж ирсэн тээврийг хэрэгслийг НББОУС 20-ын дагуу бусад орлогыг бүртгээгүй.	1	1,145.3			1	1,145.3	1	1,145.3	-	-	-	-
Хьюндай экуйс маркийн тээврийн хэрэгсэлд шинээр тавьсан АВС моторыг засварын зардлаар бүртгэсэн.	1	7,288.6			1	7,288.6	1	7,288.6	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг дутуу тооцсон.	1	3,768.4			1	3,768.4	1	3,768.4	-	-	-	-
Хуримын үйлчилгээний орлогыг дутуу тайлагнасан.	1	1,382.7			1	1,382.7	1	1,382.7	-	-	-	-
Орлогын татварын зардлыг зөрүүтэй тооцсон.	1	230.1			1	230.1	1	230.1	-	-	-	-
Дүн	8	75,256.5			8	75,256.5	8	75,256.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа борлуулалтын орлогод эзлэх барааны өртөг харилцан адилгүй орлого, өртгийг өөр өөр сард бүртгэсэн байна	1	2,761.4	-	-	-	-	1	2,761.4	-	-	-	-
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
Байгууллагын ахмад настанд хүндэтгэл үзүүлэхтэй холбоотой гарсан зардлыг ахмадын сангийн зардлаар бүртгээгүй.	1	3,669.4	-	-	-	-	1	3,669.4	-	-	-	-
Ажилчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх нарийвчилсан үнэлгээний шалгуур үзүүлэлт, түүнийг үнэлэх журамгүйгээр нийт ажилчдад үр дүнгийн урамшуулал хавтгайруулан олгосон	1	22,455.6	-	-	1	22,455.6	-	-	-	-	-	-
Дүн	4	28,886.4		-	2	22,455.6	2	6,430.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны хуулийн дагуу 10 мэдээллийг ил тод байршуулаагүй, 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	378,176.2	1	378,176.2	-	-
Дүн	1	3781,76.2	1	378,176.2	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж буй тээврийн хэрэгслийн дугаарын дэвсгэр өнгийг өөрчилж бүртгүүлээгүй.	1	-	-	-	1	-
Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүйгээр шууд худалдалт хийсэн.	1	36,200.0	1	36,200.0		
Тайлант хугацаанд арилжааны банкнаас хүлээн авсан хүүгийн орлогын дүнд цахим төлбөрийн и баримт олгоогүй, дотоод бараа, үйлчилгээний суутгасан НӨАТ (ТТ-03а) тайланд чөлөөлөгдөх орлогоор тайлагнаагүй	1	62,490.1	-	-	1	62,490.1
Дүн	3	98,690.1	1	36,200.0	2	62,490.1
Нийт дүн	4	476,866.3	2	414,376.2	2	62,490.1